

ХУУЛЬ САХИУЛАГЧИЙГ ЭСЭРГҮҮЦЭХ ГЭМТ ХЭРГИЙГ ХУУЛЬЧИЛЖ ИРСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

THE CRIME OF RESISTING LAW ENFORCEMENT HISTORICAL TRADITIONS THAT HAVE BEEN LEGALIZED

В.Амарсанаа

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн
тэнхимийн багш, доктор (Ph.D), цагдаагийн хошууч*

Товч агуулга: 1921 оны Ардын хувьсгалаас хойшхи хугацааны Эрүүгийн хууль тогтоомжид хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг хуульчилсан байдал, түүний онцлогийг нээн илрүүлж, одоо хэрэгжиж буй Эрүүгийн хуульд заасан энэ төрлийн гэмт хэрэгтэй харьцуулах замаар шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт хийж, санал дэвшүүлэхийг зорилоо.

Abstract: Within the framework of the article, The aim is to make scientific conclusions and propose proposals by discovering the specifics of anti-law enforcement crimes in the criminal codes of the period since the 1921 people's revolution, when Mongolia was independent, and comparing them with those in the current Criminal Code.

Түлхүүр үгс: Ардын хувьсгал, засгийг төлөөлөгч, олон нийтийн байцаагч, төрийн албан хаагч, хууль сахиулагч, Шүүх цаазын бичиг.

Keywords: Revolution, government representative, public inspector, civil servant, law enforcer, judicial executioner's letter.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийг Ардын хувьсгал ялж, Анхдугаар Үндсэн хуулийг боловсруулах ажлыг эхлүүлсэн 1921 оноос хойш тооцож үзвэл, 1926, 1929, 1934 оны Шүүх цаазны бичиг, 1942, 1961, 1986, 2002 оны Эрүүгийн хууль нь залгамж чанартай, тухайн цаг үеийн улс төр, үзэл суртлыг агуулсан шинжтэй байсан хэдий ч түүхэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэж иржээ⁸⁵. Ю.Цэдэнбал 1960 онд зохион байгуулагдсан, хуулийн байгууллагуудын удирдах ажилтнуудын хамтарсан зөвлөгөөн дээр “Хөдөлмөрчдийн чинээлэг аж байдал, соёлын хэмжээ, тэдний социалист ухамсар, жилээс жилд дээшилж байна. Ингэхлээр гэмт хэрэг гарах нийгмийн шалтгаан тасран, арилжээ. Гэмт хэрэг хийх явдал гагцхүү хуучин заншлаас болох болжээ. Шударга ажиллахгүйгээс амьдралын зүйлийг хулгай, хуурамч аргаар олох, хүмүүжил сулаас нийгмийн хэв журмыг өвдэх, анхаарал, сахилгагүйгээс осолдож, цалгардаад, гэмт хэрэг гаргах ийм шалтгаанаар, гэмт хэрэг гарч байна. Эдгээр шалтгааныг арилгаж болох уу? Болно. Үүнийг багасгасаар байгаад гэмт хэрэг гарах явдлыг бүр мөсөн устгаж болох юм”⁸⁶ гэжээ. Их удирдагч Ю.Цэдэнбал 1960 онд “...гэмт хэргийг үндсээр нь устгаж болно” хэмээн итгэлтэй өгүүлж байсан явдал нь тухайн үеийн нийгмийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал өндөр хэмжээнд хангагдаж, өмнөх зуунтай харьцуулахад иргэдийн ухамсар өөр түвшинд хүрсэнээс гадна Эрүүгийн хууль тогтоомж гүйцэтгэх үүргээ хангалттай биелүүлж, механизм нь тогтвортой ажилласантай холбоотой юм. Мэдээж хэрэг, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, нийгмийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй албан хаагчидгүйгээр нийгмийн аль ч цаг үед улс орны тогтвортой байдал хангагдах боломжгүй билээ. Маршал Ю.Цэдэнбал “...гэмт хэргийг үндсээр нь устгаж болно” гэж зүгээр ч нэг, сэтгэлийн хөөрлөөр хэлээгүй бөгөөд, ийн өгүүлэхдээ хууль сахиулагчдын сайн үйл ажиллагаа болон эрх зүйн зохицуулалт хоёрт үндэслэж, итгэлтэйгээр мэдэгдэл хийсэн болов уу. Эндээс хууль сахиулагчдын нийгмийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн хэвийн үйл ажиллагаа явуулах, хуулийг хэрэгжүүлсний төлөө амь нас, эрүүл мэнд, эрх зүйн

⁸⁵ URL: /https://mojha.gov.mn/-аас үзэв.

⁸⁶ Залуу үеийг эрдэм мэдлэгтэй, ажилч, хичээнгүй хүмүүс болгон хүмүүжүүлье. УБ. 1960. 49 дэх тал.

хангамжид байх голлох хамгаалалт болсон үе үеийн Эрүүгийн хуулиудад заасан, хууль сахиулагчийн эсрэг гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагын тогтолцоог тусгасан байдлыг судлах хэрэгцээ урган гарч байна.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг 1926 оны Шүүх цаазны бичигт тусгасан байдал

1921 онд ардын хувьсгал ялж, Монгол ардын нам засгийн эрхийг гартаа авсны дараа нийгэмд тэр чигт нь эмх замбараатай байдлыг бий болгож, ёс суртахууныг төлөвшүүлэн, шударга ёсыг тогтоох шаардлага зүй ёсоор тавигдсан байна. Ардын хувьсгалын гол зорилго нь тусгаар тогтнолоо олох явдал байсан боловч уг хувьсгалын үр дүн нь нийгмийн эрс өөрчлөлт авчирч чадсан байна. 1911 оны хувьсгалаар Богд хааныг ширээнд нь залж, шашин төрийг хослуулан бариулсан бол 1921 оны хувьсгалаар ч мөн Богд хааныг ширээнд нь залсан хэдий ч эрх мэдлийг хязгаарлан зөвхөн билэг тэмдгийн төдий буюу шашны хэргийг хамааруулсан нь шашин төрийн хэргийг тусгаарласан, илүү ардчилсан засаглал тогтоосон ач холбогдолтой болжээ. Мөн уг хувьсгалаар нийгмийн хөгжилд саад тогтор болж байсан феодализм, хамжлагат ёсыг халсан байна. Хамжлагат ёсыг халсанаар нийгэмд шударга ёс тогтох үндэс бүрдсэн бөгөөд, иргэдийн аж амьдралыг сайжруулах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагаа явуулах нь юу юунаас чухал ажил болж хувирав.

Нийгмийн хэрэгцээ, шаардлагаас улбаалан, Монгол Улсын анхны Эрүүгийн хууль болох шүүх цаазны бичгийг 1926 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр баталж, ялын тогтолцоо, төрлийг тодорхойлж, ял оногдуулах үндэслэл, журмыг нарийвчлан хуульчилснаараа онцлогтой байсан. Уг Шүүх цаазны бичгийн 11 дүгээр бүлэг (Улсын засаг захиргаанд тэрслэхүй нь)-т алба татвар үл тушаах, нуун дарагдуулах, цэргийн албанаас зайлсхийх, цэргийн дайчилгаанаас зайлсхийх гэх зэрэг гэмт хэргээс гадна бидний судалж буй хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг нь “Албан тушаалтныг эсэргүүцэх, албан үүргээ зөрчихийг хүчирхэн албадах” гэсэн нэршлээр оршиж, энэ төрлийн харилцааг зохицуулж байжээ. Тодруулбал, энэ хуулийн 65 дугаар зүйлд “Аливаа хүн, аливаа албан тушаалтны оноосон албыг гүйцэтгэх дор тушаалыг эсэргүүцэн үл дагах буюу тушаалтны аливаа хэргийг зүй бусаар шийтгүүлэхийг хичээж хүчирхэн албадахдаа алах аваас цаазаар авбал зохино. Түүнчлэн шархтуулан дутуу тахир болгох буюу бусад зүйлээр дарлан доромжилвоос 6 сараас 5 жил хүртэл гянданд хорино” гэж, 66 дугаар зүйлд “Хэрэв дээрхи зүйл дор дурьдсан гэмт явдлыг үйлдэхдээ албан тушаалтны бие дор гэм хийсэн ба дарлан доромжилсон зүйл үгүй аваас 6 сар хүртэл гянданд хорино”⁸⁷ гэж заажээ. 66 дугаар зүйлд заасан үйлдэл нь 65 дугаар зүйлд заасан “...тушаалыг эсэргүүцэн үл дагах буюу тушаалтны аливаа хэргийг зүй бусаар шийтгүүлэхийг хичээж хүчирхэн албадахдаа алах аваас... Түүнчлэн шархтуулан дутуу тахир болгох буюу бусад зүйлээр дарлан доромжилвоос...” гэж тус тус дурдсан хохирол, хор уршгийг учруулаагүй тохиолдолд, албан тушаалтныг эсэргүүцсэн хэмээн үзэж, хариуцлага хүлээлгэдэг байсныг харж болохоор байна. Өөрөөр хэлбэл, Шүүх цаазны бичгийн 66 дугаар зүйл нь албан тушаалтанд хүч хэрэглэлгүйгээр эсэргүүцэх үйлдэлд тусад нь хариуцлага хүлээлгэдэг тогтолцоог анх гаргасан буюу одоогийн Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгтэй төстэй байна. 67 дугаар зүйлийн араас “Тайлбарлах нь” хэсэг нэмэгдэж, “Аливаа албан тушаалтныг албаа эс явуулсан цагт боловч, түүний албаны явдлын тухай бөгөөд олны өмнө доромжилбоос энэхүү зүйлд дурьдсан ёсоор шийтгэвээс зохино” гэж нэн шинэ тайлбар оруулсан явдал нь албан тушаалтан эрхэлсэн албаа гүйцэтгэхээс бусад цаг хугацаанд байснаас үл хамааран, гэмт этгээдийн зүгээс албан үүргээ гүйцэтгэсэнтэй нь холбогдуулан доромжлох үйлдэлд хариуцлага хүлээлгэх ойлголт бөгөөд, хууль сахиулагчийн нэр төр, алдар хүндийг хамгаалсан дэвшилттэй

⁸⁷ Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. I – дэвтэр. УБ. 1998. 17, 18 дахь тал.

алхам болсон. Уг Шүүх цаазны бичгийн дурдсан зүйлүүдэд заасан байдлаас үзэхэд, хууль сахиулагчийг эсэргүүцэх, албадах, амь бие, эрүүл мэндэд нь халдах үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцож, нэлээд хүнд хариуцлага хүлээлгэхээс гадна албан тушаалтны биед учирсан гэмтлийн хэр хэмжээг тогтоох болон доромжилсон үйлдэлд хариуцлага хүлээлгэх оролдлого хийгдсэн нь сайшаалтай байна. Мөн Шүүх цаазны бичгийн санкц хэсэгт албан тушаалтныг аливаа албан хэргийг зүй бусаар шийтгүүлэхийг хичээж, хүчирхэн албадахдаа алах аваас буудан алваас зохимой, шархдуулан дутуу тахир болгох бусад зүйлээр дарлан доромжилсон аваас 6 сараас 5 жил хүртэл хоримой гэж заасан нь төрийн албыг хашиж байгаа албан тушаалтнуудын нийгмийн баталгаа, амь бие, эрүүл мэндийг хамгаалахад чухал ач холбогдолтой хууль болсон гэж үзэж болохоор байна.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг 1929 оны Шүүх цаазны бичиг тусгаасан байдал

1929 оны Шүүх цаазны бичиг нь бүтэц, агуулгын хувьд өмнөх хуулиас ялгагдах үндсэн өөрчлөлтгүй боловч гэмт хэрэг, ялын тухай асуудлын онолын үндэслэлийг улам боловсронгуй болгох, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдлүүдийг бүрэн тусгах замаар, нийгэм, иргэдийн эрх ашгийг эрүүгийн хуулийн хамгаалалтад авах зорилгыг хангасан гэж үзэж болно⁸⁸. Тэгэхээр 1929 оны Шүүх цаазны бичиг цоо шинэ, бие даасан хууль биш, 1926 оны “Шүүх цаазны бичиг”-ийн шинэчлэн найруулсан хэлбэр гэж үзэж болно⁸⁹.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг Шүүх цаазны бичгийн 10 дугаар бүлэг (Улсын засаг захиргаанд тэрслэх нь)-т хамааруулан, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байна. Тодруулбал, 70 дугаар зүйлд “Аливаа хүмүүн албан тушаалтны оноосон албыг гүйцэтгэхэд тушаалыг эсэргүүцэн үл дагах буюу тэрхүү тушаалтны аливаа албан хэргийг зүй бусаар шийтгүүлэхийг хичээж хүчирхэн албадахдаа алах аваас буудан алваас зохимой. Түүнээс шархдуулан дутуу тахир болгох бусад зүйлээр дарлан доромжилсон аваас 6 сараас 5 жил хүртэл хоримой” гэж 1926 оны Шүүх цаазны бичигт зааснаас огт ялгаагүй байдлаар хуульчилсан байна. 71 дүгээр зүйлд “Хэрвээ дээрх зүйлүүд дор дурьдсан гэмт явдлыг үйлдэхдээ албан тушаалтны бие дор гэмт хор хийсэн ба дарлан доромжилсон зүйл үгүй аваас 6 сар хүртэл хорих буюу 300 төгрөг хүртэл торговоос зохимой” гэж өмнөх хуультай ижил байдлаар хуульчилсныг нарийн задалбал дараах хэд хэдэн бага зэргийн өөрчлөлтүүд орсон байна.

1929 оны Шүүх цаазны бичиг нь 1926 оны Шүүх цаазны бичгийн бүтэц, системээс төдийлөн ялгаагүй байдлаар хэлбэржсэн бөгөөд, найруулгын хувьд илүү ойлгомжтой, хэрэглэхэд хялбар болсон байна. Харин албан тушаалтныг эсэргүүцэх гэмт хэргийн бүтэц, агуулга, санкцид ямар нэгэн өөрчлөлт оруулаагүй, тэр хэвээр нь баталсан нь өмнөх хуулиас ялгагдах өөрчлөлтгүйгээр тусгагдсан болохыг харуулж байна.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг 1934 оны Шүүх цаазны бичигт тусгаасан байдал

1934 оны Шүүх цаазны бичгийг 1934 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн Сайд нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тухайн сарын 24-ний өдөр Улсын бага хурлын тэргүүлэгчдийн газраас 6 бүлэг 41 зүйлтэйгээр, тусгай ангийг 8 бүлэг 113 зүйлтэйгээр 1934 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн сайд нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, мөн оны 10 дугаар сарын 8-ны өдөр Улсын бага хурлын тэргүүлэгчдийн газраас батлан гаргасан байна. Тус Шүүх цаазны бичгийг батлан гаргах болсон шалтгаан нь 1929 оны Шүүх цаазны бичигт элдэв гэмт хэргүүдийг бүлэг бүрийн зохих зүйлүүдэд хутгалдуулан

⁸⁸ Баярсайхан Б., Жанцан С., Энхнасан Ж., Сумъяацэрэн Д. Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ. 2011. 86 дахь тал.

⁸⁹ Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. I – дэвтэр. УБ. 1998. 35 дахь тал

бичсэн, хувьсгалд тэрсэлсэн гэмт хэргүүдийг хэдэн бүлэг болгон бичсэнээс гадна, аж ахуй, албан тушаал ялангуяа хурьцлын гэмт хэргүүдийн ялыг хөнгөн заасан зэрэг дутагдлууд гарсан учир уг хуулийг шинэчлэн зохиож өөрчлөн явуулсан байна⁹⁰.

1934 оны Шүүх цаазны бичигт анх удаа түүний зорилтыг “Шүүх цаазны бичиг зарласан нь Ардын хувьсгалт засаг ба улс хийгээд тогтоосон хэм хэмжээнд харшлах олон нийтийн дор аюул бүхий хэргүүдээс хамгаалах зорилготой бөгөөд тийнхүү хамгаалахдаа уул үндсэн хүмүүст энэ шүүх цаазны бичигт заасан ёсоор шийтгэх ялуудыг хэрэглэмой”⁹¹ гэж өмнөх хуульд байгаагүй зорилтыг тодорхойлжээ.

Уг Шүүх цаазны бичигт Засаг захиргааны журмыг эсэргүүцэх онц аюултай гэмт хэргүүд гэсэн 2 дугаар бүлэгт “Шүүн таслах явдал дор тэрслэх”, “Засгийг төлөөлөн яваа этгээдийг эсэргүүцэх, хүчирхэн дарлах” зэрэг олон бүлгүүдийг задлан хуульчилсан бөгөөд, хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн хувьд, үндсэн бүрэлдэхүүнийг энэ хуулийн 70 дугаар зүйлд “Хэн нэгэн хүнээс засгийг төлөөлөн яваа этгээд болох албан тушаалтнаас хуулиар даалгагдсан уул албан үүргийг гүйцэтгэхэд эсэргүүцэх буюу засаг захиргааны газруудаас хууль ёсоор тушаасныг үл гүйцэтгэх” гэж тодорхойлоод, хүндрүүлэх бүрэлдэхүүнийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Хэрэв засгийг төлөөлөх этгээд нарыг хүчирхэн дарласан бол 1 жилээс доошгүй хугацаагаар хорих ял шийтгэвэл зохино.

2. Засгийн төлөөлөх этгээд нарыг хүчирхэн дарлахгүйгээр эсэргүүцсэн бол 6 сар хүртэлх хугацаагаар хорих буюу мөнхүү хугацааны дотор албадан ажил хийлгэх, эсвээс 600 төгрөг хүртэл торгож шийтгэвэл зохино.

3. Засгийн төлөөлөх этгээд нарыг албан үүргээ явуулж бүхий цаг үест олны өмнө доромжилбол 3 сар хүртэлх хугацаагаар хорих буюу 6 сар хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсвээс 300 төгрөг хүртэл торгож ял шийтгэвэл зохино.

4. Албан тушаалын хүмүүс буюу олон нийтийн ажилчныг тэдгээрийг уул албан үүргийг гүйцэтгэн буй цаг үест ална хэмээх буюу хөрөнгө хогшлийг бутарган сүйтгэнэ, хүчирхэн дарлана хэмээн занавал 1 жил хүртэл хугацаагаар хорих буюу 6 сар хүртэл албадан ажил хийлгэх, эсвээс 1200 төгрөг хүртэл торгож ял шийтгэвэл зохино⁹².

Энэхүү Шүүх цаазны бичигт 1926, 1929 оны Шүүх цаазны бичигт заасан албан тушаалтныг алсан бол цаазаар авах (буудан алах) ялыг хасаж, засгийг төлөөлж байгаа хүмүүсийг эсэргүүцсэн, хүчирхэн дарласан, хүчирхэн дарлахгүйгээр эсэргүүцсэн, доромжилсон, заналхийлсэн бол ял шийтгэхээр заасан бөгөөд, ялын төрөлд торгох, албадан ажил хийлгэх ялыг нэмэлтээр оруулсан байна. Мөн анх удаа буудан алах ялыг туйлын хүнд гэмт хэрэгт хэрэглэх, харин насанд хүрээгүй хүмүүс ба жирэмсэн, хөхүүл, нялхас, эмэгтэйчүүдэд хэрэглэхийг хориглосон нь нэлээд энэрэнгүй хууль болсон гэж үзэж болохоор байна.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг 1942 оны Эрүүгийн хуульд тусгасан байдал

Монгол ардын хувьсгалт намын 1940 оны X дугаар их хурлаас төрийн байгууллагын үйл ажиллагааг хөнгөн, шуурхай болгох, нийгмийн амьдралд гарсан шинэ өөрчлөлт, шаардлагыг тусган, БНМАУ-ын Үндсэн хуулийг өөрчлөн, зохиож, түүнтэй уялдуулан бусад хууль тогтоомжуудыг боловсронгуй болгох, хууль ёс, улсын сахилгыг бэхжүүлэн, ард иргэдийн эрхийг элдэв хэлбэрийн халдлагаас хамгаалах явдлыг хувьсгалын зорилтыг хэрэгжүүлэх нөхцөл гэж үзсэн байна. 1940 оны 6 дугаар сард хуралдсан VIII их хурлаар БНМАУ-ын шинэ Үндсэн хуулийг шинэчлэн баталж, улмаар 1942 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр Улсын XXV бага хурлаас Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийг 6 бүлэг, 54 зүйл, тусгай ангийг 10 бүлэг 165 зүйлтэйгээр

⁹⁰ Баярсайхан Б., Жанцан С., Энхнасан Ж., Сумъяацэрэн Д. Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ. 2011. 90 дэх тал.

⁹¹ Мөн тэнд. 90 дэх тал.

⁹² Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. I – дэвтэр. УБ. 1998. 83, 84 дэх тал.

батлан гаргасан байна. Энэ хуулиар нийгэм, төр, байгууллага, иргэдийн өргөн агуулгатай эрх ашиг, сонирхлыг хамгаалалтад авсан бөгөөд, өмнөх хуулиудтай харьцуулбал, тогтолцоо бүтэцийн хувьд илүү боловсронгуй болсон гэж үзжээ⁹³.

Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн түүхэнд анх удаа “БНМАУ-ын Эрүүгийн хууль” нэртэйгээр батлан гаргасан уг хуульд тухайн үеийн нийгмийн хөгжлийн цаг үеийн шаардлагаас улбаалан, нэлээд олон нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг. Үүний нэг жишээ нь хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг юм. Тус хуулийн 3 дугаар (Засаг захиргааны журмыг эсэргүүцсэн бусад гэмт хэргүүд) бүлгийн 94 дүгээр зүйлд “Засгийг төлөөлөн яваа хүмүүсээс тэдгээрт хууль ёсоор даалгасан албан үүргийг гүйцэтгэхэд эсэргүүцэх буюу засаг захиргааны байгууллагын хуулиар тушаасныг үл гүйцэтгэхдээ засгийг төлөөлж яваа хүмүүсийг хүчирхэн дарласан байвал нэгэн жилээс доошгүй хугацаагаар хорьж шийтгэвэл зохино.

Хэрэв эл явдлыг засгийг төлөөлж яваа хүмүүсийг хүчирхэн дарлалгүйгээр үйлдсэн байвал нэгэн жил хүртэл хугацаагаар хорих буюу албадан ажил хийлгэж шийтгэх буюу 1000 төгрөг хүртэл торговол зохино”⁹⁴ гэж заажээ. Өмнөх хуулиудтай харьцуулахад албан тушаалтны хууль ёсны үйл ажиллагаатай холбогдуулан амь биед нь халдах үйлдлийг хуулиас хасаж, зөвхөн хүчирхэн дарлаж, эсхүл хүчирхэн дарлалгүйгээр эсэргүүцсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцсон байна. Хууль сахиулагч албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдуулан доромжлох үйлдлийг гэмт хэрэгт тооцох жишгийг баримталж, энэ хуулийн 98 дугаар зүйлд дараах байдлаар тусгасан. Үүнд: Засгийг төлөөлөн яваа хүмүүсийг албан үүргээ биелүүлж байхад олны өмнө дайран доромжилбол нэгэн жил хүртэл хугацаагаар хорих буюу албадан ажил хийлгэх буюу 1000 төгрөг хүртэл торговол зохино⁹⁵.

Засаг захиргааны журмыг эсэргүүцэх гэмт хэргүүд нь ардын хувьсгалт засаг төрийг түлхэн унагаах явдалд шууд зориулагдсан бус боловч засаг захиргаа ба улс, ардын аж ахуйн хэвийн үйл ажиллагааг эвдэх байдалд хүргүүлж, засаг захиргааны байгууллагад эсэргүүцлийг гаргах буюу тэдгээрийн ажиллагаанд саадыг учруулсан, мөн түүнчлэн хууль тушаалуудыг дагаж үл биелүүлэх зэргээр засгийн алдар нэр ба хүчнийг сулруулсан тийм явдлууд болно⁹⁶.

Энэхүү хуульд “Засаг захиргааны журмыг эсэргүүцсэн бусад гэмт хэргүүд” гэх нэртэйгээр хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг заасан бөгөөд, буудан алах ялыг хувьсгалт төр засаг хийгээд, улс нийтэд онц аюултай хүнд гэмт хэрэг үйлдэгчид оногдуулах онцгой ял болгон найруулжээ. Мөн “Хувьсгалт төр засагт эсэргүү хандсан буюу ардын хувьсгалт засгаас явуулсан хууль журмыг зөрчин үйлдсэн буюу эс үйлдсэнээр нийтэд аюултай явдлуудыг гэмт хэрэг” гэж тодорхойлсоноос үзэхэд, засгийг төлөөлөн яваа хүмүүсийг алсан тохиолдолд улс нийтэд онц аюултай гэмт хэрэгт тооцон, ял оногдуулах боломжтой байсан гэж үзэж байна. Энэ хуульд засгийг төлөөлөн яваа хүмүүсийг эсэргүүцсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлага нь мөн л нэлээд энэрэнгүй шинжтэй хуульчлагдсан бөгөөд, өмнөх хуулиудтай харьцуулахад хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлсэн хууль болсон.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг 1961 оны Эрүүгийн хуульд тусгасан байдал

БНМАУ-ын Их хурлын 4 дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 1960 оны 7 дугаар сарын 6-ны өдөр зохион байгуулагдаж, түүхэндээ гурав дахь Үндсэн хуулийг батлан гаргасан. Энэхүү суурь хуульд Эрүүгийн хуулийг нийцүүлэн боловсруулж, 1961 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр АИХ-ын II чуулганаар баталж, мөн оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн түүхтэй. Уг хуулийн Ерөнхий анги 5 бүлэг 44

⁹³ Баярсайхан Б., Жанцан С., Энхнасан Ж., Сумъяацэрэн Д. Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ. 2011. 94 дэх тал.

⁹⁴ Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. I – дэвтэр. УБ. 1998. 123 дахь тал.

⁹⁵ Мөн тэнд. 124 дэх тал.

⁹⁶ Мөн тэнд. 118 дахь тал.

зүйлтэй, тусгай анги 11 бүлэг 221 зүйлтэйгээр батлагдан гарсан байна. Судлаач Б.Баярсайхан нар “Эрүүгийн хуулийн зорилгыг 1 дүгээр зүйлд “Тусгаар тогтнол, төрийн бүрэн эрх, нийгмийн болон төрийн байгууламж, социалист өмч, иргэдийн амь бие, эрх, эрх чөлөө, хуулиар тогтоосон хэв журам зэрэг энэ хуулиар хамгаалагдах нийгэм, төр, байгууллага, иргэдийн амин чухал эрх ашиг, сонирхлыг нэрлэж заасан нь шинэлэг юм” гэж тодорхойлсон⁹⁷.

Тус хуульд Цагдан сэргийлэх байгууллагын ажилтан, цагдан сэргийлэх байгууллагад туслах болон олон нийтийн бригадын гишүүдийн алдар нэр хүнд, эрүүл мэнд, амь биед халдсан гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх журмыг БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1962 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 204 дүгээр зарлигаар тогтоосныг 155¹, 155², 155³ дугаар зүйл болгон системчилсэн байна.

Өмнөх Эрүүгийн хуулиудыг бодвол, хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг Тусгай ангийн нэлээд хойгуур оруулан, өмнө нь төрийн эсрэг гэмт хэргүүд, социалист өмчийн эсрэг гэмт хэргүүд, иргэдийн амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө ба нэр алдарт харшлах гэмт хэргүүд, иргэдийн элс төр, хөдөлмөрийн эрхийн эсрэг гэмт хэргүүд, иргэдийн амины өмчийн эсрэг гэмт хэргүүд, тэр ч байтугай социалист аж ахуйн эсрэг гэмт хэргүүд, албан тушаалын гэмт хэргүүд болон шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргүүдийг оруулсан явдал нь хууль сахиулагчийн үйл ажиллагааны чухал байдлыг дутуу үнэлсэн зүйл болсон гэж үзэж байна.

Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 9 дүгээр бүлэг (Засаг захиргааны журам эсэргүүцсэн гэмт хэргүүд)-т хууль сахиулагчийг эсэргүүцэхтэй холбоотой нийт гурван зүйл ангийг багтааж, дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

155 дугаар зүйл. Засгийн төлөөлөгч буюу олон нийтийн хэв журмыг хамгаалах үүрэг гүйцэтгэж байгаа олон нийтийн төлөөлөгчийг эсэргүүцэх, тэднийг доромжлох

а) Засгийн төлөөлөгчийг албан үүргээ гүйцэтгэж байхад буюу олон нийтийн төлөөлөгчийг олон нийтийн хэв журам хамгаалах үүргээ гүйцэтгэж байхад нь эсэргүүцэх, хүч хэрэглэх, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж тэднийг хууль бус үйлдэл хийлгэхээр тудган хавчвал 3 жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэнэ.

б) Энэ зүйлийн “а”-д дурьдсан хүмүүсийн албан үүргээ гүйцэтгэж байхад олон нийтийн өмнө доромжилбол 1 жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу 300 төгрөг хүртэл торгох эсхүл олон нийтийн өмнө арга хэмжээ авахуулна⁹⁸ гэж заасан. Уг зүйлд “засгийн төлөөлөгч”, “олон нийтийн төлөөлөгч” гэх нэр томъёо шинээр гарсан бөгөөд, зөвхөн эдгээр нэрсэд хамаарах албан хаагчдыг эсэргүүцсэн, эсхүл доромжилсон тохиолдолд, уг зүйлээр хариуцлага хүлээлгэхээр заасан байдлаараа онцлогтой байна.

155² дугаар зүйл. Цагдан сэргийлэх байгууллагын ажилтан, цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригадын гишүүдийг эсэргүүцэх

а) Олон нийтийн хэв журам сахиулах үүргээ гүйцэтгэж байх үед нь цагдан сэргийлэх байгууллагын ажилтан, цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригадын гишүүдэд эсэргүүцэл үзүүлсэн этгээдийг 2 жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жил 6 сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл 500 хүртэл төгрөгөөр торгож шийтгэнэ.

б) Энэ гэмт хэргийг үйлдэхдээ хүч хэрэглэхээр заналхийлсэн буюу хүч хэрэглэсэн цагдан сэргийлэх байгууллагын ажилтан, цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригадын гишүүдэд хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж, хууль бус үйлдэл хийлгэхээр тулган шаардсан байвал 3 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

⁹⁷ Баярсайхан Б., Жанцан С., Энхнасан Ж., Сумъяацэрэн Д. Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ. 2011. 102 дахь тал.

⁹⁸ Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. I – дэвтэр. УБ. 1998. 191 дэх тал.

в) Энэ гэмт хэргийг үйлдэхдээ бүлэглэсэн буюу цагдан сэргийлэх байгууллагын ажилтан, цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригадын гишүүдийн биед хөнгөн гэмтэл учруулсан байвал 7 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. (БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1966 оны 11-р сарын 2-ны өдрийн 143 дугаар зарлигаар нэмэгдсэн).

Уг зүйл ангид анх удаа “цагдан сэргийлэх байгууллагын ажилтан”, “цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригадын гишүүн” гэх нэршил гарсан нь цагдан сэргийлэх байгууллага байгуулагдаж, нийгмийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэж эхэлсэнтэй холбоотой юм. Тодруулбал, МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчоо Цагдан сэргийлэх байгууллагын ажлын тухай хэлэлцээд, 1957 оны 7 дугаар сарын 16-ны өдөр Улсын цагдан сэргийлэх газрын ажлыг сайжруулах, ажиллах нөхцөл бололцоогоор хангах талаар авах арга хэмжээний тухай 19 тоот тогтоол гаргажээ. Тогтоолд, цагдан сэргийлэх байгууллага нь ардчилсан төрийн хууль дүрмийг биелүүлэх, улсын ба ард иргэдийн эрх ашгийг хамгаалах, олон нийтийн хэв журмыг сахиулах, улс, олон нийтийн өмч хөрөнгийг идэж ашиглах, хулгайлах явдалтай тэмцэх үүрэг хүлээлгэсэн. Үүргийг хамгаалалттай нь хамт хэлбэржүүлсэн гэхэд хилсдэхгүй юм.

155³ дугаар зүйл. Цагдан сэргийлэхийн ажилтан, цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригадын гишүүдийн биед халдаж гэмтэл учруулах

Олон нийтийн хэв журам сахиулах албан үүрэгтэй нь холбогдуулан цагдан сэргийлэх байгууллагын ажилтан, цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригадын гишүүдийн биед халдаж хүнд гэмтэл учруулбал хоёроос таван жил хүртэл хугацаагаар нутаг зааж суулгах буюу суулгахгүйгээр таваас арван таван жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ. Хэрэв хүндрүүлэх шалтгаан байвал БНМАУ-ын Эрүүгийн хуулийн 70 дугаар зүйлийн “а”-д зааснаар цаазаар авна. (БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1966 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн 143 дугаар зарлигаар нэмэгдсэн)⁹⁹. Уг зүйл анги нь цагдан сэргийлэхийн ажилтан, цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийтийн бригадын гишүүдийн эрүүл мэндийн халдашгүй байдал, амь насыг гэмт халдлагаас хамгаалж, оногдуулах хариуцлагыг хүндрүүлсэн явдал нь хууль сахиулагчид нийгмийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ итгэлтэйгээр гүйцэтгэх хөшүүрэг болсноороо чухал ач холбогдолтой.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг өмнөх хуулиудад засгийг төлөөлж яваа хүмүүс, аливаа албан тушаалтан гэж ерөнхий байдлаар хуульчилсан байсан бол энэ хуульд анх удаа цагдан сэргийлэхийн ажилтнууд болон цагдан сэргийлэхэд туслах олон нийтийн бригадын гишүүд гэж тодорхой нэр томъёо, ялгаа заагтай хуульчилж, засгийн төлөөлөгчдийг эсэргүүцэх гэмт хэргийг тусад нь хуульчилснаараа нэлээд онцлогтой болсон. Мөн цагдан сэргийлэхийн ажилтнууд болон цагдан сэргийлэхэд туслах олон нийтийн бригадын гишүүдийн биед халдах болон хөнгөн, хүнд гэмтэл учруулбал хүлээлгэх хариуцлагыг нэг бүрчлэн тодорхой зааж өгсөн бөгөөд, оногдуулах ялын хэмжээг нэлээд өндөр хуульчилж өгсөн явдал нь сайшаалтай байна.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг 1986 оны Эрүүгийн хуульд тусгасан байдал

1961 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт орсоор 25 жилийн турш төрийн эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл байсан боловч түүний олон хэм хэмжээ гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцлийн тухайн үеийн шаардлагад илтэд нийцэхгүй болсон, төр, нийгэм, иргэдийн амин чухал олон эрх ашиг эрүүгийн хуулийн хамгаалалтын гадна үлдсэн нь хийдэл үүсэх шалтгаан болсон бөгөөд, хууль сахиулах зарим байгууллагуудын ажилтнууд тэдгээрийг хууль бус үйл ажиллагаандаа ашиглах явдал гарч байсныг 1983 оны МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 316 дугаар

⁹⁹ Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. I – дэвтэр. УБ. 1998. 191-192 дахь тал.

тогтоолд хөдөлшгүй баримттайгаар тэмдэглээд, гэмт хэрэгтэй тэмцэх үүрэгтэй хуулиуд, тэр тусмаа эрүүгийн хуулийг хоёр жилийн дотор шинэчлэн батлах талаар өгсөн шийдвэр заалтыг хэрэгжүүлэх хүрээнд, энэ хуулийг БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 1986 оны 12-р сарын 5-ны өдрийн 217 зарлигаар шинэчлэн найруулж, 5 бүлэг, 59 зүйлтэй, тусгай анги 13 бүлэг, 301 зүйлтэйгээр батлаад 1987 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн байна¹⁰⁰.

Мөн анх удаа гэмт хэргийн ангилалт хийж, хуулийн 6 дугаар зүйлд хүнд гэмт хэргүүдийг зүйл, хэсгээр нэрлэж, заасан, гэм буруугийн хэлбэрийг хоёр зүйлд оруулан, оюун санаа, хүсэл зоригийн шинжүүдийг нарийвчлан тодорхойлсон. 1961 оноос батлагдан мөрдөгдөж 1986 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль нь бүтэц, хэлбэрийн хувьд харьцангуй сайжирсан хууль боловч социалист өмчийн харьцааг хамгаалан дэмжих, төлөвлөгөөт эдийн засаг, захиран тушаах дэглэмийн тогтвортой байдлыг энэ хуулийн албадлагаар баталгаажуулахад чиглэгдсэн заалтууд хуульд хадгалагдан үлдсэн байдаг.

1986 оны Эрүүгийн хуулийн Тусгай анги өмнөх хуулиудтай нэгэн адил Төрийн эсрэг гэмт хэргээр эхэлсэн бол хоёрдугаар бүлэг нь “Хүний амь бие, эрүүл мэнд, эрх чөлөө, нэр алдрын эсрэг гэмт хэрэг” гэсэн нэршилтэйгээр тусгагдаж, иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах зорилгыг дэд эгнээнд багтаасан байна. Харин аравдугаар бүлэг (Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг)-т хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргээс гадна амь биед халдах, доромжлох үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зааж, энэ бүлэгт системтэйгээр тусгасан байна. Тодруулбал, Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 218 дугаар зүйлд (Засгийн төлөөлөгч буюу нийтийн хэв журам хамгаалах үүрэг гүйцэтгэж байгаа олон нийтийн төлөөлөгчийг эсэргүүцэх) “Засгийн төлөөлөгчийг хуулиар оногдуулсан үүргээ гүйцэтгэж байхад нь буюу олон нийтийн төлөөлөгчийг нийтийн хэв журам хамгаалах үүргээ гүйцэтгэж байхад нь эсэргүүцсэн, эсхүл хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж тэднийг илт хууль бус үйлдэл хийлгэхээр албадсан нь энэ хуулийн 220 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй бол” гэж заасан бөгөөд 220 дугаар зүйл (Цагдаагийн байгууллагын ажилтан буюу ардын нөхөрлөлийн гишүүнийг эсэргүүцэх)-ийн үндсэн бүрэлдэхүүнд “Цагдаагийн байгууллагын ажилтан буюу ардын нөхөрлөлийн гишүүнийг нийгмийн хэв журам хамгаалах талаар оногдсон үүргээ гүйцэтгэж байхад нь хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн бол” гэж, хүндрүүлэх бүрэлдэхүүнд “Энэ үйлдлийг хийхдээ хүч хэрэглэсэн буюу хүч хэрэглэхээр заналхийлж тэднийг илт хууль бус үйлдэл хийлгэхээр албадсан бол” гэж буюу 218 дугаар зүйлд заасан үйлдлүүдийг ангилж тусгасан. Үүнээс гадна өмнөх хуулиудын нэгэн адил хууль сахиулагчийн амь биед халдахыг тусгай зүйл ангиар (222 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын ажилтан буюу ардын нөхөрлөлийн гишүүний амь биед халдах) зохицуулж, “Нийгмийн хэв журам хамгаалах албаны болон олон нийтийн үйл ажиллагаатай нь холбогдуулан цагдан сэргийлэх байгууллагын ажилтан буюу нийгмийн хэв журам хамгаалах ардын нөхөрлөлийн гишүүний амь биед халдсан бол нутаг заах буюу заахгүйгээр таваас арван таван жил хүртэл хугацаагаар хорих буюу хэрэв хүндрүүлэх нөхцөл байдалтай бол цаазаар авах ял шийтгэнэ гэж” заасан байна. Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 218 болон 220 дугаар зүйлд заасан гэмт хэрэг нь өөр хоорондоо онцын ялгаагүй бөгөөд, зөвхөн халдлагад өртөгчөөрөө ялгаатай. Тодруулбал, 218 дугаар зүйлийн халдлагад өртөгч нь засгийн төлөөлөгч буюу нийтийн хэв журам хамгаалах үүрэг гүйцэтгэж байгаа олон нийтийн төлөөлөгч байх бол 220 дугаар зүйлийн халдлагад өртөгч нь цагдаагийн байгууллагын ажилтан буюу ардын нөхөрлөлийн гишүүн байхаар тусгагдсан байна.

Судлаачид “Энэ хуульд гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож болохгүй гэсэн үндсэн хуулийн тулгуур заалтыг суулгасан. Гэмт хэргүүдийг нийгмийн хор аюул ялын байдал, хэмжээ, хэлбэр, гэм бурууг харгалзан хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилсан нь

¹⁰⁰ Баярсайхан Б., Жанцан С., Энхнасан Ж., Сумъяацэрэн Д. Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ. 2011. 108 дахь тал.

Эрүүгийн хууль хэрэглэх үйл явцыг боловсронгуй болгосон¹⁰¹ гэж дүгнэжээ. Бидний судалж буй сэдвийн хүрээнд хэрэгжүүлэх зорилгоор хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэх эрх зүйн хамгаалалтыг системтэй¹⁰² тусгасан байдлаараа дэвшилттэй байна.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг 2002 оны Эрүүгийн хуульд тусгасан байдал

1980-аад оны дунд үеэс Баруун Европын социалист тогтолцоотой зарим улсууд тэрчлэн ОХУ-д өрнөсөн өөрчлөлт, шинэчлэлт, ил тод байдлыг үзэл санааны нөлөө Монгол улсад хүчтэй нэвтэрч, улмаар 1990 оны эхээр манай улсын нийгэм, улс төр, эдийн засгийн хуучин тогтолцоог үндсээр нь өөрчилсөн ардчилсан хувьсгал ялах нөхцөл болсон бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулгад нийцүүлсэн бусад хуулиудыг бүхэлд нь шинэчлэх шаарлага тулгарсан. Иймээс 1986 оны Эрүүгийн хуульд хэд хэдэн удаа томоохон хэмжээний нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан бөгөөд, энэ нь улс төрийн ардчилсан дэглэмтэй, хүний эрхийг эрхэмлэн дээдэлсэн төрийн зохицуулалт бүхий зах зээлийн эдийн засгийн тогтолцоотой эрх зүйт төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой байсан.

Эрүүгийн хуульд бараг жил тутам шахуу элдэв өөрчлөлт оруулж, засварлах арга хэмжээ авч байсан хэдий ч, шинэ нөхцөл байдалд үр дүнтэй үйлчлэх боломжгүй байдалд шууд хүргэж байсан, хуучирсан олон хэм хэмжээ, хийдэл, хоцрогдолыг засах, эрүүгийн хуулийн хамгаалах чиг үүргийг өндөржүүлэх, Үндсэн хуулийн агуулга, үзэл санаа, нийгмийн эдийн засгийн шинэ тогтолцооны бодит хэрэгжилтэнд нийцүүлэх шаардлагууд нь Эрүүгийн хуулийг бүхэлд нь шинэчлэх үндэслэл болсон юм. Эрүүгийн шинэ хуулийг 2002 оны 1 дүгээр сарын 03-ны өдөр ерөнхий ангийг 4 хэсэг, 13 бүлэг, 78 зүйлтэйгээр, тусгай ангийг 7 хэсэг, 16 бүлэг, 225 зүйлтэйгээр баталж, 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн¹⁰³.

Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлсэн, ардчилсан тогтолцоог бэхжүүлэхэд анхаарал хандуулахыг зорьж, Эрүүгийн хуулийн зарчмуудад хүний эрхийг хамгаалах чиглэлийн үзэл баримтлалыг ихээр шингээж, Эрүүгийн хуулийн Тусгай ангийн бүтэц, тогтолцоонд өөрчлөлт оруулсан боловч аливаа төрийн эсрэг гэмт хэргийг чухалчлан үздэг байсан жишиг хэвээр үлдсэн.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг Эрүүгийн хуулийн Тусгай ангийн бүлгүүдийн нэлээд хойгуур тусгасан. Тодруулбал, хорин зургадугаар бүлэг (Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг)-ийн 230 дугаар зүйлд хуульчилж, уг зүйл ангийг хүндрүүлэх болон онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр тусгаж, оногдуулах ял шийтгэлийн асуудлыг дараах байдлаар хуульчилсан. Үүнд:

230 дугаар зүйл. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх

230.1 Төрийн албан хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэж байхад нь болон олон нийтийн байцаагчийг хэв журам сахиулах үүргээ биелүүлж байхад нь хүч хэрглэн эсэргүүцсэн буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн, түүнчлэн хууль бус үйлдэл хийлгэхээр албадсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нааяас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гурван

¹⁰¹ Мөн тэнд. 111 дэх тал.

¹⁰² 1986 оны Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 219 дүгээр зүйл (Засгийн төлөөлөгч буюу нийгмийн хэв журам хамгаалах үүрэг гүйцэтгэж байгаа олон нийтийн төлөөлөгчийг доромжлох)-д, 221 дүгээр зүйл (Цагдаагийн байгууллагын ажилтан буюу ардын нөхөрлөлийн гишүүнийг доромжлох)-д тус тус хууль сахиулагчийг доромжлохтой холбоотой харилцааг зохицуулж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Энэ нь хууль сахиулагчийг албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбоотойгоор системтэйгээр хамгаалж байгаагийн илрэл юм.

¹⁰³ Баярсайхан Б., Жанцан С., Энхнасан Ж., Сумъяацэрэн Д. Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ. 2011. 108 дахь тал.

зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

230.2 Энэ хэргийн улмаас төрийн албан хаагч болон олон нийтийн байцаагчийн бие махбодид хөнгөн, хүндэвтэр гэмтэл учирсан бол гурван зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

230.3 Энэ хэргийн улмаас төрийн албан хаагч болон олон нийтийн байцаагчийн бие махбодид хүнд гэмтэл учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ¹⁰⁴.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх үйлдлээс гадна тэдний биед учирч болзошгүй гэмтлийн зэргийг тусгаж, гэмтлийн төрлөөс хамааран ял шийтгэлийн асуудал хүндрэх болсон нь өмнөх Эрүүгийн хуулиудаас дэвшилттэй тал нь болжээ. Мөн халдлагад өртөгчийн хамрах хүрээг илүү өргөжүүлэн¹⁰⁵, “төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч” гэж зааж өгсөн явдал нь энэ төрлийн гэмт хэргийн улмаас төрийн албан хаагчид хохирох эрсдлийг арилгахад чухал нөлөө үзүүлсэн. Өмнөх хуулиудтай харьцуулахад хууль сахиулагчийн амь биед халдах үйлдлийг Захиргааны журмын эсрэг гэмт хэргийн бүлгээс хасаж, Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргийн бүлэгт, 91 дүгээр зүйл (Хүнийг санаатай алах)-ийн 2 дахь хэсгийн 2.17 (...албаны үйл ажиллагаа буюу олон нийтийн үүргээ биелүүлж байгаатай нь холбогдуулан хүнийг өөрийг нь буюу түүний ойрын төрөл, садангийн хүнийг алсан бол арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ)-д тусгайлан заасан.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг 2015 оны Эрүүгийн хуульд тусгасан байдал

Монгол улс ардчилсан нийгэмд шилжин орсон тул хүний эрхийг дээдэлсэн хуулийг батлан гаргах шаардлага үүссэний зэрэгцээ өмнөх хууль нь практикт хэрэглэхэд төвөгтэй, ялын бодлогын хувьд үр нөлөө багатай олон зүйл, заалтыг төрийн бодлого, нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэхийн тулд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын шинэ Эрүүгийн хуулийг 2015 онд Монгол Улсын Их Хурлаар баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн үйлчилж, хамгийн сүүлд 2020 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Шинэ Эрүүгийн хууль нь үзэл баримтлал, зорилго, зорилтын хувьд бусад хуулиас нэлээд өөр байдлаар тусгагдаж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалахыг нэн тэргүүний зорилго болгож, хүний амь бие, эрүүл мэнд, халдашгүй байдлыг анхааран үзэж, улмаар Эрүүгийн хуулийн Тусгай ангийн бүтэц, тогтолцоонд томоохон өөрчлөлт оруулсан. Эрүүгийн хуулийн Тусгай анги Төрийн эсрэг гэмт хэргийн бүлгээр эхэлдэг байсныг өөрчилж, Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргийг тусгасан нь нийгэм дэх хүний үнэ цэнэ өссөний тод жишээ юм.

Хэдийгээр хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдлыг тэргүүн эгнээнд хамгаалсан боловч хууль сахиулагчийг хамгаалах тогтолцоо үндсэндээ алдагдсан гэж хэлж болно. Учир нь урьд урьдны Эрүүгийн хуулиудад хууль сахиулагчийг эсэргүүцэх, амь биед нь халдах, доромжлох үйлдлүүдийг тус тусад нь зүйл ангиар тодорхойлон хуульчилж, хариуцлага хүлээлгэдэг байсныг үгүй болгож, зөвхөн хууль сахиулагчийг эсэргүүцэх үйлдлийг гэмт хэрэгт тооцож, Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 23.1 дүгээр зүйл (Хууль сахиулагчийг эсэргүүцэх)-д хуульчлан тодорхойлсон байдлаас харж болно. Тодруулбал, Эрүүгийн хуулийн Тусгай ангийн хорин гуравдугаар бүлэг (Нийтийн

¹⁰⁴ Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2002. №5. 230 дугаар зүйл.

¹⁰⁵ Эрүүгийн хуулийн 230 дугаар зүйлийн тайлбар хэсэгт “Энэ хуулийн 230, 231 дүгээр зүйлд заасан төрийн албан хаагч гэдэгт шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтан, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч нарыг хамруулан ойлгоно” гэж заасан.

албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг)-т заасан. Уг зүйлийн үндсэн бүрэлдэхүүнд “Хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн” үйлдлийг багтаасан бол 2 дахь хэсэгт “Энэ гэмт хэргийг: Галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж; Хууль сахиулах албаны тоног төхөөрөмж, барилга, байгууламжид халдаж үйлдсэн бол хүндрүүлэхээр заасан байна.

2002 оны Эрүүгийн хуульд заасантай харьцуулахад хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн үед хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан тохиолдолд энгийн бүрэлдэхүүнтэй гэмт хэргийн хүндрүүлэх шинжээр, тодруулбал, Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 11.1-ийн 2 дахь хэсгийн 2.1, 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр тус тус зүйлчилж, хариуцлага хүлээлгэхээр заасан бөгөөд, хууль сахиулагчийг хууль сахиулах албаны тоног төхөөрөмж, барилга, байгууламжид халдаж эсэргүүцсэн тохиолдолд хүндрэхээр тогтоосон.

Дүгнэлт

Анхдугаар Үндсэн хуулийг 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталж, хувьсгалын ялалтыг хуульчлан бэхжүүлж, ард иргэдийнхээ эрхийг тунхаглан зарлаж өгсөн бөгөөд 1926 онд манай улсын анхны төрөлжсөн Эрүүгийн хуулийг “Шүүх цаазны бичиг” нэртэйгээр батлан гаргасан нь нийгэмд шударга ёс тогтох, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд маш том алхам болсон. Уг хуульд Аливаа албан тушаалтны оноосон албыг эсэргүүцэх, албан тушаалтны аливаа хэргийг зүй бусаар шийтгүүлэхийг хичээж хүчирхэн албадах, албан тушаалтныг доромжлох, албан тушаалтны аливаа хэргийг зүй бусаар шийтгүүлэхийг хичээж, хүчирхэн албадах зэрэгт хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг хуульчилж, хүлээлгэх хариуцлагыг чангаар тогтоосноор төрийн алба хааж байгаа албан тушаалтнуудын эдлэх эрх, нийгмийн баталгаа, амь бие, эрүүл мэндийг иж бүрнээр хангасан.

“1929 оны Шүүх цаазны бичиг нь бүтэц, агуулгын хувьд өмнөх хуулиас ялгагдах үндсэн өөрчлөлт ороогүй, 1926 оны Шүүх цаазны бичгийн шинэчлэн найруулсан хэлбэр гэж үзэж болно” гэж судлаачдын үзсэнтэй санал нийлж байна. Учир нь 1929 оны Шүүх цаазны бичгээс гадна 1934 оны Шүүх цаазны бичигт заасан хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэг нь 1926 оны Шүүх цаазны бичигт зааснаас онцын ялгаагүй байдлаар хуульчлагдсан гэж үзэх үндэстэй байна.

Өмнөх хуулиудтай харьцуулахад 1942 оны Эрүүгийн хуульд албан тушаалтны хууль ёсны үйл ажиллагаатай холбогдуулан амь биед нь халдах үйлдлийг хуулиас хасаж, зөвхөн хүчирхэн дарлаж, эсхүл хүчирхэн дарлалгүйгээр эсэргүүцсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцсон явдал нь хууль сахиулагчийн амь биед халдах үйлдэлд хүлээлгэх хариуцлагын тогтолцоонд ухралт болсон гэж үзэх үндэстэй юм. Уг хуулийн 94 дүгээр зүйлийн үндсэн бүрэлдэхүүний дараах хэсэгт “Хэрэв эл явдлыг засгийг төлөөлж яваа хүмүүсийг хүчирхэн дарлалгүйгээр үйлдсэн байвал” гэж заасан нь одоогийн Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 23.1 дүгээр зүйлд заасан “хууль сахиулагчийг эсэргүүцэх” үйлдлийн хүч үл хэрэглэн эсэргүүцэх хэлбэрийг тодотгосон явдал болжээ.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийг өмнөх хуулиудад засгийг төлөөлж яваа хүмүүс, аливаа албан тушаалтан гэж ерөнхий байдлаар хуульчилсан байсан бол 1961 оны Эрүүгийн хуульд анх удаа цагдан сэргийлэхийн ажилтнууд болон цагдан сэргийлэхэд туслах олон нийтийн бригадын гишүүд гэж тодорхой нэр томъёо, ялгаа заагтай хуульчилж, тэдгээрийн биед халдах болон хөнгөн, хүнд гэмтэл учруулбал хүлээлгэх хариуцлагыг нэг бүрчлэн тодорхой зааж өгсөн бөгөөд, оногдуулах ялын хэмжээг нэлээд өндөр хуульчилж, ялгамжтай байдлаар тогтоосон байдлаараа өмнөх хуулиудаас ялгаатай юм.

1986 оны Эрүүгийн хуульд анх удаа Цагдан сэргийлэх байгууллагын ажилтан, цагдан сэргийлэх байгууллагад туслах болон олон нийтийн бригадын гишүүдийн нэр төр, алдар хүнд, эрүүл мэнд, амь биед халдах гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан нь 1926, 1929, 1934 оны Шүүх цаазны бичгүүдтэй төстэй бөгөөд, ялгагдах онцлог нь анх удаа уг гэмт хэргийн хохирогч нь цагдаагийн байгууллагын ажилтан байх

онцлогийг тодорхойлоод зогсохгүй, дан ганц цагдаагийн байгууллагын ажилтныг эсэргүүцсэн үйлдэлд бус, бусад төрлийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалахад мөн адил чиглэсэн байдлаараа давуу талтай гэж үзэж байна.

1990 оны ардчилсан хувьсгалаас хойш улс орны нийгэм, эрх зүйд томоохон өөрчлөлтүүд явагдсаны нэг илрэл нь 2002 оны Эрүүгийн хууль юм. Урьд захиргааны журмын эсрэг гэмт хэрэг Эрүүгийн хуулийн бүтцэд нэлээд чухал байр суурь эзэлж, бүлгүүдийн өмнө байрлаж байсан бол 2002 оны Эрүүгийн хуульд бусад ашиг сонирхлоос харьцангуй хойгуур (23 дугаар бүлэг) тусгасан явдал нь энэ төрлийн харилцааны чухал байдлыг алдагдуулсан гэж дүгнэх үндэстэй юм. Давуу тал нь хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнээс гадна хууль сахиулагчийн биед учруулсан гэмтлийн зэргээс хамаарч, хүндрүүлэх болон онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр тусгаж, оногдуулах ял шийтгэлийг нэмэгдүүлсэн явдал юм.

Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуульд хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн бол гэж хуульчилсан байгаа бөгөөд ялын төрөл нь торгох, зорчих эрхийг хязгаарлах, хорих, оногдуулах, ялын хэмжээ нь өмнөх хуулиуд буюу ардын хувьсгалын дараах үеийн хуулиудтай харьцуулбал нэлээд уян хатан, ялын хэмжээ бага байгаа нь харагдаж байна. Мөн тус хуульд хууль сахиулагчийн бие, эрх чөлөөнд халдаж эрүүл мэндэд нь хохирол учруулсан үед ямар хариуцлага тооцох талаар тусгаагүй байгаа бөгөөд практикт хууль сахиулагчийн эрүүл мэндэд хохирол учруулбал тус хуулийн 11 дүгээр бүлэгт заасан “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-тэй давхар зүйлчлэхээс өөр аргагүй байдалд хүргэж байгаа юм. Гэтэл уг гэмт хэрэг нь захиргааны журмын эсрэг гэмт хэрэгт хамаардаг, үндсэн шууд объект нь хууль сахиулах байгууллагын хэвийн үйл ажиллагаа юм.

Хууль сахиулагчийг эсэргүүцэх, тэднийг доромжлох, нэр төр, алдар хүндэд нь халдахаас гадна амь биед нь халдах гэмт хэргийг ардын хувьсгалаас хойшх цаг хугацаанд анхааран үзэж, зохих эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зааж, хууль сахиулагчийн амь бие, эрүүл мэнд, нэр төр, алдар хүндийг системтэй хамгаалж ирсэн түүхэн уламжлалыг халж, зөвхөн хууль сахиулагчийг эсэргүүцэх үйлдэлд Эрүүгийн хариуцлага хүлээлгэх болсон явдал нь одоогийн хэрэгжиж буй Эрүүгийн хуулийн системгүй байгаагийн илрэл юм.

Санал

Үе үеийн Эрүүгийн хуулиудад хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэрэгт хариуцлага оногдуулж ирсэн түүхэн уламжлалыг алдагдуулахгүй байх, цаашлаад нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй хууль сахиулагчдын амь бие, эрүүл мэндийг Эрүүгийн хуулиар тал бүрээс нь, системтэй хамгаалах зорилгоор Эрүүгийн хуульд хууль сахиулагчийн амь биед халдах гэмт хэргийг тусгай бүрэлдэхүүнээр хуульчилж, нэмэлтээр оруулах саналтай байна.

2002 оны Эрүүгийн хуулийн 230 дугаар зүйл (Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг эсэргүүцэх)-д хууль сахиулагчийг эсэргүүцэх гэмт хэргийн улмаас төрийн албан хаагчид болон хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчдын бие махбодид учирсан гэмтлийн зэргээс хамаарч, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэхээр заасан жишгийг сэргээж, 2015 оны Эрүүгийн хуулийн 23.1 дүгээр зүйлд тусгах саналтай байна.

Ашигласан материал

1. Адъяабазар Д. Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. I – дэвтэр. УБ. 1998.
2. Баярсайхан Б., Жанцан С., Энхнасан Ж., Сумъяацэрэн Д. Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ. 2011.

3. Жанцан С. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. /Гэмт хэргийн тухай сургааль/. I боть. УБ. 2009.
 4. Залуу үеийг эрдэм мэдлэгтэй, ажилч, хичээнгүй хүмүүс болгон хүмүүжүүлье. УБ. 1960.
 5. Эрүүгийн хууль //Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ. 2002. №5.
- Цахим эх сурвалж:
6. /<https://mojha.gov.mn/>.
 7. /<http://uridchilan-sergiileh.police.gov.mn/>.